



боломжгүй байсан шашны хэргэм зэргийг зуу зуун хандмаа нар олж эзэмшихээр тэмүүлж байна. 1987 онд Сакядитагийн үйл ажиллагаа эхэлснээр хойш өмнө нь төсөөлөгдөөгүй байсан ажлууд хийгдсээр байна. Үндэсний болон орон нутгийн Сакядита салбарууд сууриа тавьж эмэгтэйчүүдийг орон нутгийн болон үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах боломжтой болгоод байна. Сакядита сэтгүүл нь гишүүд ээ шинэ мэдээллээр, шинэ төслүүд, өгүүллэгүүдээр цаг алдалгүй хангадаг. Вэб сайт нь Буддийн шашинт эмэгтэйчүүдэд чиглэгдсэн судалгааны ажил, шинэ санаа мөн туршлага



хуваалцах мэдээлэл солилцох бүх мэлээллээр хангадаг. Цуврал өгүүллэгүүд нь Буддийн шашинт эмэгтэйчүүдийн түүх тэдгээрийн амьдралийн түүхэн бичиг баримт зэргийг шинэчлэн хэвлэж нийтлэхэд тусладаг. Буддист эмэгтэйчүүд хамтдаа нэгдэж тэдний нийгмийн болон сүсэг бишрэлийн онцгой чадварыг ашиглахаар хамтраад байна.

Бид таныг бидэнтэй нэгдэж дэлхийн Буддист эмэгтэйчүүдий нийгмийн амьдралыг сайжруулахаар сурч боловсрч, дадлага эзэмших өргөн хүрээтэй эх үүсвэрт хамтран ажиллахыг урьж байна. Та гишүүнчлэлээ Сакядита олон улруу илгээнэ үү!



САКЯДИТА ГИШҮҮНЧЛЭЛ

Сакядита-д нэгдэж Буддийн шашинт эмэгтэйчүүдийг дэмжицгээе!

- Би Сакядита-д нэгдэхийг хүсэж байна
- Би Сакядита гишүүнчлэлээ шинэчлэхийг хүсэж байна
 - \$300 Насан туршийн гишүүнчлэл
 - \$150 Насан туршийн гишүүнчлэл (хандмаа, оюутан, ажилгүйчүүд)
 - \$150 Энэрэгч
 - \$75 Дэмжигч
 - \$30 Энгийн гишүүн
 - \$15 Хандмаа, оюутан, ажилгүйчүүд
- Нэмэлт орлогын татварт нэмэр өгөх \$ _____

ШРИФТЭЭР БИЧНЭ ҮҮ!

Нэр: _____

Хаяг: _____

Хот: _____

Орон нутаг: _____

Улс: _____

Утас гэр: _____

Утас ажил: _____

Электрон шуудангийн хаяг: _____

Шинэ санаа болон сонирхолууд: _____

Please include a check or money order
in U.S. dollars only.

Thank you for your support!



sakyadhita
international association of buddhist women

923 Mokapu Blvd.
Kailua, HI 96734 USA
www.sakyadhita.org

САКЯДИТА

БУДДИЙН ШАШИНТ
ЭМЭГТЭЙЧҮДИЙН ОЛОН
УЛСЫН ХОЛБОО



САКЯДИТА БУДДИЙН ШАШИНТ ЭМЭГТЭЙЧҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО

Сакаядита буюу Буддагийн охидууд, дэлхийд тэргүүлэгч Буддийн шашинт эмэгтэйчүүдийн олон улсын байгууллага нь эмэгтэйчүүдийн амьдралыг Буддист нийгэмд шилжүүлэхээр зорьсон эмэгтэйчүүдийн нэгдэл юм. Энэхүү олон улсын нэгдэл нь 1987 онд Энэтхэг улсын Бодхгая хотноо болсон Буддийн шашинт эмэгтэйчүүдэд чиглэгдсэн олон улсын хурлын шийдвэр дээр үндэслэгдсэн. Сакаядита нь өөр өөр орнуудын өөр өөр уламжлал соёлтой Буддийн шашинт эмэгтэйчүүдийн амар амгаланг хангах мөн тэдний хүмүүнлэгийн ажилд тусламж үзүүлэх тал дээр анхаарч ирсэн.



Манай эрний өмнөх зургадугаар зуунд, Будда нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн оюуны сүнслэг чадвар тэнцүү гэдгийг баталсан. Энэхүү батламж нь эмэгтэйчүүдийн биологийн зохилдлого нь ажлын бүтээмжтэй хөдөлмөрч ажилчин гэж давамгайлсан үзэж байсныг өөрчлөхөд мэдэгдэхүйц нөлөөлсөн юм. Буддизм нь ихэнх шашны дунд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш оюуны сүнслэг чадвартай гэж үздэгээрээ онцгой юм. Харамсалтай нь ихэнх Буддист орчин дахь эмэгтэйчүүд энэ тэгш эрхийг эдлэх боломжгүй байсаар байна.

Ойролцоогоор дэлхий даяар зуун гучин мянган хандмаа нартай нийлээд гурван зуун сая Буддист эмэгтэйчүүд байна гэсэн тоо гарсан. Эдгээр эмэгтэйчүүдийн ихэнх нь боловсрол эзэмших болон Буддийн шашны зан үйлийг сурах боломжгүй



ядуу нөхцөлд амьдарч байна. Хэдийгээр Будда эрэгтэй эмэгтэйчүүдийн оюуны сүнслэг чадвар, сүсэг бишрэлийг тэгш гэж үзэн гандан хийдэд эзлэх эмэгтэйчүүдийн хэргэм зэргийг гаргаж ирсэн боловч эрэгтэйчүүдийн эзлэх хувь, ноёрхол оршин тогтносоор байна. Одоогоор зөвхөн Хятад, Солонгос мөн Вьетнам зэрэг орнуудад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийнхтэй адил сахил хүртэх эрхтэй байгаа юм.

Сакаядитагийн гишүүд Буддийн шашин дахь эрэгтэй эмэгтэйчүүд тэгш эрхтэй байж шашны зан үйлийн боловсрол, хэргэм зэргийг эдлэх тэгш эрхт боломжоор хангагдахын төлөө ажиллаж байна. Энэ гишүүд нь Эрдэмтэд, шашны зан үйлийг сурган хүмүүжүүлэгчид, багш нар, өмгөөлөгч хуулийн байгууллагынхан, жүжигчид урлаг соёлынхон, холбоо нийгэмлэгийн зохион байгуулагчид, энэрэнгүй үйлсийн идэхтнүүд гэсэн өөр өөр мэргэжил боловсрол бүхий хүмүүс нэгдэж эмэгтэйчүүдийн чадварыг хөгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж байна. Сакаядитагийн зорилгууд нь:

Олон улсын Буддийн шашинт эмэгтэйчүүдийн нэгдэлийг бий болгож зохион байгуулах

Дэлхийн эмэгтэйчүүдийн шашинлаг болон шашинлаг бус амар амгаланг дэвшүүлэх

Буддийн шашны боловсрол, сургалт, зохион байгуулалтын бүтэц болон дэс дараанд хүйсийн асуудлыг тэнцвэржүүлэхээр ажиллах

Буддийн шашны уламжлал болон түүний үзэл санааг бусад шашны үзэл санаатай зохицуулах



Буддийн шашинт эмэгтэйчүүдэд чиглэгдсэн судалгааны ажил явуулах, өгүүллэг бичих сонирхлыг дэмжих дээр анхаарч уриалах

Хүмүүнлэг энэрэнгүй нийгмийг дэмжих

Буддийн шашныг зааж сургаснаар дэлхийн энх тайванд дэмжлэг үзүүлэх нь

Буддийн шашинт эмэгтэйчүүдэд чиглэгдсэн Сакаядита олон улсын хуралд оролцсоноор эмэгтэйчүүдийг асар мх мэдээллээр хангаж нийгмийн идэвхийг байгалиас нь хөгжүүлдэг. Одоогоор, Сакаядита Олон Улсын Хурал нь Бодхгая (1987), Бангкок (1991), Коломбо (1993), Ладакх (1995), Пномпень (1998), Лумбини (2000), Тайбэй (2002), Сөүл (2004), Куала-Лампур (2006), Монголд (2008) мөн Вьетнам (2010) гэсэн орнуудад зохион байгуулагдсаар ирсэн. Дараагийн хурал нь 2010 оны 7-р сард Тайланд улсад зохион байгуулагдахаар төлөвлөгдөөд байна.

Энэхүү цугларалтаар дэмжигдэн эмэгтэйчүүд маань бясалгалын шинэ төв, сургалтын төслүүд, сүм хийдүүд мөн эмэгтэйчүүдийн байрлах байр зэргийг шинээр байгуулсан. Мөн түүнчлэн үндэсний болон орон нутгийн хурлууд, туршлага хуваалцах уулзалт, сургалтын бүлгэм, өөр бусад төслүүд зэрэгийг эхлүүлсэн. Өнөөдөр мянга мянган эмэгтэйчүүд Буддийн шашин болон тэдгээрийн холбоодод шинэ шинэ үүрэг хүлээсээр байна. Өмнө нь зарим улсуудад